



**УВС АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn

2020. 11.30 № 302

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,  
СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА, ЗАСАГ  
ДАРГА, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД,  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ,  
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН УДИРДЛАГУУДАД

Шударга ёс, сахилга, хариуцлагыг  
тогтоох үүрэг чиглэл хүргүүлэх тухай

Шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан төрийн үйлчилгээг иргэдэд эрх тэгш, ил тод, нээлттэй хүргэдэг хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор дараах үүрэг чиглэлийг хүргүүлж байна.

**1.Аймгийн Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллах:**

- 1.1. Засаг даргын Тамгын газрын харъяа хэлтсийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудын биелэлт, хуулиар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилт, ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргүүдийн биелэлт, төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэл тооцох,
- 1.2 Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, санал, хүсэлтийн шийдвэрлэлт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүрд нь дүгнэх, гарсан үр дүн, гүйцэтгэлтэй уялдуулан ажилтнуудад цалин хөлс, урамшуулал олгох, хариуцлага тооцох журмыг мөрдөх,
- 1.3 Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах, гүйцэтгэлийн явц, үр дүнд хяналт тавих, хариуцлагыг чангатгах, төрийн албаны хууль, журам, стандартыг мөрдүүлэх,
- 1.4 Төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, архидан согтуурах, сахилга, ёс зүйн зөрчилд хатуу арга хэмжээг авч ажиллах,
- 1.5 Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага тооцож, эерэг орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах,
- 1.6 Агентлаг, хэлтэс, албадын дарга нарын ажлын тайланг хагас, бүтэн жилээр сонсох, дүгнэх,
- 1.7 Нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн захиргааны байгууллагын уялдаа холбоог сайжруулах,
- 1.8 Төрийн албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, иргэдээс бүрдсэн хяналтын зөвлөлийг бий болгох,
- 1.9 Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар, удирдлагын менежментийг сайжруулах зорилгоор судалгаанд суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй, орон нутгийн онцлогт нийцсэн цогц бодлогыг боловсруулах,

8520910155

- 1.10 Аймгийн нэгдсэн эмнэлэгт иргэдэд түргэн шуурхай, хүнд сурталгүй үйлчилдэг нэгдсэн цахим тогтолцоог бий болгох,
- 1.11 Эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавх, эмч нарын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах,
- 1.12 Аймгийн хэмжээний ажилгүй иргэдийн судалгааг гаргаж, тэдгээрийг аймаг, орон нутагт ажлын байраар хангах арга хэмжээ авах, цаашид ажлын байрны шаардлага хангахгүй байгаа иргэдийн мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, шинээр их дээд сургууль төгсөгчдийн ур чадварыг ахиулах, давтан мэргэшүүлэх, дадлагажуулах зорилгоор Улсын чанартай Төмөр зам, Эрчим хүч, Барилга, Уул уурхай зэрэг томоохон бүтээн байгуулалттай газруудад ажиллуулах замаар ажилгүйдлийн түвшинг үе шаттайгаар бууруулах цэгцтэй бодлого, төлөвлөгөө боловсруулах,
- 1.13 Аймаг, сумын төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын 2016-2020 оны шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, шилэн дансыг нөхөж хөтлүүлэх,
- 1.14 Аймгийн хэмжээнд бүх нийтээр ашиглах “Смарт-Увс” аппликейшнг хөгжүүлж, иргэдийг мэдээ мэдээллээр тогтмол хангах, өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж ажиллах,
- 1.15 Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дунд СӨХ байгуулах төлөвлөгөө боловсруулж ажиллах,
- 1.16 Хотын гэрэлтүүлэг, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор төр, хувийн хэвшил хоорондын хамтран ажиллах менежмент төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх,
- 1.17 Гадаадын хамтын ажиллагаатай /Хятад, Тайвань, Солонгос, ОХУ-ын Тува / зэрэг улс орнуудтай цахим хэлбэрээр холбогдож хамтран ажиллах,
- 1.18 Аймгийн хэмжээнд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд ЖДҮ, бизнес эрхлэгч, зах, худалдааны төв, үйлчилгээний газруудын түрээслэгч нарын түрээсийн төлбөрийг уян хатан нөхцөлтэйгээр хөнгөлөх асуудлыг холбогдох газруудтай тохиролцон шийдвэрлэх арга хэмжээг авах,
- 1.19 Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сумын төрийн байгууллага, хуулийн этгээдүүдийг хуульд заасан хэмжээний хөрөнгийг төлөвлөх, зарцуулахад хяналт тавьж ажиллах,
- 1.20 Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үргүй зардлыг бууруулах, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах,
- 1.21 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр 2016-2020 оны хооронд худалдан авсан авто машин, бусад техник хэрэгслүүд, тэдгээрийг эзэмших,

ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, өмчийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, төрийн байгууллагын авто машины нэгдсэн бааз /парк/ бий болгож ажиллах,

**1.22** Тэтгэмж, группд орох асуудалд танил тал харах, авилга, хээл хахууль авах, эрүүл иргэдийг группд хамруулж зарим өвчтэй иргэдийг хасдаг байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах, цаашид тэтгэмж олгох, группэд хамрагдах үйл ажиллагааг ил тод, шударга, шилэн тогтолцоонд шилжүүлж хүндрэл, чирэгдэлгүй шийдвэрлэдэг тогтолцоог бий болгох,

**1.23** Аймгийн хэмжээнд халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, айл өрхийн судалгааг гаргаж, халамжийн 10 нэр төрлийн 72 үйлчилгээнд тухайн зорилтот бүлгүүд хамрагдсан эсэхэд хяналт тавих,

**1.24** Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрны асуудал, мөн төрөөс үзүүлж буй дэмжлэг үйлчилгээнд хамрагдаж чадаж байгаа эсэх, хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүдийн судалгаа мэдээллийг гаргаж холбогдох арга хэмжээг авах,

**1.25** Тэтгэврээ тогтоолгосон мөртлөө ажиллаж буй тэтгэврийн насны хүмүүсийг ажлаас чөлөөлж тухайн ажлын байранд ил тод, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах гэсэн үүрэг чиглэлүүдийг хүргүүлж байна.

## **2. Сумдын ИТХ, Засаг дарга, төрийн байгууллагууд болон орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлагуудад:**

**2.1.** Төрийн албанд шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр түвшинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

**2.2** Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох аливаа оролдлогыг тухай бүр нь таслан зогсоох, авилга, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх,

**2.3** Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй эрх тэгш харьцах, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2020 оны 12 сарын 15-ны дотор багтаан шийдвэрлэж хариу өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах, ард иргэдийн санал хүсэлт гомдол хүлээж авах нээлттэй утас ажиллуулах,

**2.4** Төрийн албан хаагчдын ажлын байранд дүн шинжилгээ хийж, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах,

**2.5** Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын байрны дэг журмыг баримтлах, аливаа ажил, үйлчилгээг цаг хугацаанд нь шуурхай зохион байгуулж хэвшүүлэх,

- 2.6 Байгууллагын ажлын төлөвлөгөө, ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг сар, улирал, бүтэн жилээр тогтмол үнэлж, дүгнэх болон цалин хөлс, урамшуулал олгох, хариуцлага тооцох асуудлыг хэрэгжүүлэх,
- 2.7 Төрийн бүх шатны байгууллагад гарсан ажлын байрны сул орон тоонд хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, хөндлөнгийн нөлөөгүй, шударга явуулах, тухайн ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, нийтэд мэдээлэх, төрийн албаны хууль болон бусад хууль тогтоомжид заасан шалгуур хангасан хүнийг ажилд томилох,
- 2.8 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй цахим мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж зохион байгуулж байх,
- 2.9 2016-2020 оны хооронд байгууллагын шилэн дансны хөтлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цаг хугацаандаа гаргасан байдал, шилэн дансны мэдээлэл тасарсан үеийн мэдээллийг нөхөж оруулж ажиллах,
- 2.10 Өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган эрсдэлийн үнэлгээ хийж ажиллах,
- 2.11 Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд сумын төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүй зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж ажиллах,
- 3.1. Дээрх үүрэг, чиглэлийн биелэлтийг улирал бүр аймгийн ИТХ-ын ажлын албанд ирүүлж байх.

ДАРГА  Ц.БАТБОЛД

